

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ БА ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ (Ажиглалт-судалгааны зарим тайлбар, дүгнэлтүүд)

Монголын телевизүүдийн сүүлийн 2-3-долоо хоногийн хөтөлбөрүүд ба нэвтрүүлгүүдэд хийсэн ажиглалтын жишээ, баримт ба дүгнэлтүүд энд байна.

Хөтөлбөрийн бүтэц, ямар сэдэв, асуудал давамгайлдаг, бас ямар нь орхигдож буюу үгүйлэгдэж байгаа, тэгээд тодорхой нэвтрүүлгүүд ямар асуудлыг хэрхэн үзүүлсэн бэ гэдгийг ажиглалаа. Тэгээд энэ бүгдийг олон нийтийн эрх ашиг гэсэн өнцгөөс харахыг хичээлээ.

Олон нийтийн эрх ашиг гэдэг ойлголтыг томъёолоход түвэгтэй. Хэрвээ өргөн олон нийтэд буюу аль болох олон хүнийг татаж чадах уу гэсэн утгаар хандвал манай телевизийн нэвтрүүлгүүд чадна. Үзэгчдийг шууд татдаг зугаа цэнгэлийн буюу цэнгээнт нэвтрүүлгүүд: дуу хөгжим, мэндчилгээ, уралдаан, шоу, асуулт хариулт, ярилцлага, хошин шог, кино хангалттай байна. Мэдээллийн гэж тооцогддог зарим төрөл зүйлүүд, жишээлэхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг, ярилцлага хүртэл улам бүр шоудсан, бяцхан тоглолт шиг (жишээлбэл, UBS телевизийн "Чөлөөт бүс") сонирхолтой болж байна. Заримдаа телевизээс сэтгүүл зүй илт шахагдаж байна уу даа гэж санагддаг. Иймд телевизийг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн нэг төдий биш, харин олон нийтийн зугаа цэнгэл ба мэдээллийн хэрэгсэл гэж хэлэхээр болжээ. (Уг нь Mass Media бол Олон нийтийн (гэхдээ мэдээллийн биш, зүгээр л нийтийн) хэрэгслүүд гэсэн утгатай билээ).

Ямар ч байсан манай телевизүүд үзэгчдийг амрааж цэнгээх талдаа тийм ч муугүй гэсэн дүгнэлт хийж байна. Ялангуяа Солонгосын олон ангит кинонууд тасардаггүй, гадаадын янз бүрийн, түүний дотор хамгийн шилдэг кинонуудыг түргэн шуурхай орчуулан үзүүлж чаддаг нь үзэгчдэд таалагддаг.

Зугаа цэнгэлийн нөгөө талд телевизийн мэдээлэл, мөн нийгэм улс төрийн нэвтрүүлгүүд ямар байна юу? Юуны өмнө телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд албан ёсны мэдээллээр дүүрсэн гэдэг нь нотлогдож байна. Социалзмын үед ийм байсан, ардчиллын жилүүдэд ч үргэлжилсэн, одоо ардчиллын 14 дахь жилд яг хэвээрээ. Бид бүгд дасчихсан. Жишээлбэл, албаны мэдээллийг тэр чигээр нь уншдаг цорын ганц телевиз бол Монголын Үндэсний телевиз тэргүүтэй монголын телевизүүд. Сайндаа л албан ёсны мэдээллийг янз бүрийн хэлбэрт оруулахаас (бүрэн эхээр, тайлбартайгаар, товчилж гэх мэт) хэтэрдэггүй.

Өнгөрсөн өдрүүдэд телевизээр хамгийн их мэдээлж сурталчилсан сэдэв бол төр засгийн алба амьдрал (УИХ-ын чуулганы хуралдаан, Засгийн газрын хуралдаан, яам, агентлагийн тамгын газрын ажил, тогтоол, шийдвэрүүд, УИХ-ын гишүүд, сайд дарга нарын үйл хөдлөл (явсан, очсон, ирсэн, уулзсан, хэлсэн, мэдэгдсэн, ярилцсан, гардуулсан, бэлэглэсэн, тууз хайчилсан, оролцсон бусад арга хэмжээ, хурал цуглаан, уулзалт) байлаа. Ялангуяа МҮТВ-ийн мэдээллийн хөтөлбөр, тухайлбал "Цагийн хүрд"-ийн 80-аас дээш хувийг ийм мэдээ сурвалжлага эзэлжээ. Бусад телевизийн хувьд нэг их ялгаагүй. Тэд хичнээн "чөлөөтэй" харагдавч төр засгийн үйл явдлыг тойрон эргэлдэж байлаа.

Үзэгчид бодохдоо, телевизүүд, тэдгээрийн сэтгүүлчид тухайн өдөрт болж буй үйл явдлууд, асуудлаас хамгийн сонирхолтой ба хэрэгтэйг сонгож авч сурвалжилдаг хэмээн ойлгодог байх. Аль болох олон үзэгчдэд сонирхолтой, тухайлбал, ойролцоо агуулга, сэдэвтэй хоёр үйл явдлаас чухам алийг илүү олон хүн сонирхох вэ гэсэн шалгуураар сонгодог байх гэсэн санаа.

Гэтэл манай телевизүүд

1. Сурвалжлахад амар үйл явдлыг сонгодог.
2. Бэлэн мэдээллийг авч үзэгчдэд хүргэдэг юм байна.

"Сурвалжлахад амар" үйл явдал бол төрийн ордонд, эсвэл энд тэнд болсон хурал зөвлөгөөн, семинар, хэвлэлийн бага хурлууд. "Бэлэн мэдээлэл" гэж юу вэ? Цаанаасаа сурталчлуулахын тулд бэлтгэсэн мэдээлэл, эсвэл зохион байгуулсан хэвлэлийн бага хурлыг хэлнэ. Эрх мэдэлтэй байгууллага, албан тушаалтан, эсвэл мөнгөтэй байгууллага хүмүүс сурталчилгааг хийлгэж таарна. Ингээд телевизийн мэдээллийн сонголт нь гарцаагүй сенсаац биш л бол эрх мэдэл ба мөнгийг дагасан байна. Та бидний ярианы өгөгдөхүүн болж буй олон нийт (жирийн иргэд, нийгмийн хэсэг бүлгүүд гэх мэт)-ийн хувьд сурталчилгаа хийж хэвлэлийн мэдээ бэлтгэх, эсвэл хэвлэлийн бага хурал хийж телевизийн дуранд өртөх гэсэн боломж төдийгүй идэвх хязгаарлагдмал.

Ингээд манай телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд хурлаар дүүрсэн. Хэрвээ та, танай байгууллага хэвлэлийн бага хурал хийлгэж чадвал тэр оройжингөө, маргааш өглөөжин бүх телевизээр гарна. Хурлыг хамгийн ихээр бэлэнчилж сурвалжилдаг учраас манайд төр засгийн төдийгүй төрийн бус болон бусад байгууллага, хүмүүсийн ажлын үндсэн хэлбэр хурал болж хувирсан байна. Улмаар "хурлын сурвалжлага" гэсэн шинэ төрөл бүрэлдэж маш сайн хөгжжээ. Хурлыг сурвалжилсан мөртөө түүнийг огт дурдахгүйгээр тэнд яригдсан асуудлуудыг нэвтрүүлээд өнгөрч чадаж байна. Заримдаа хурлыг тойруулан баахан юм ярьж, эсвэл ургуулж цаад хурлаасаа хэд дахин сонирхолтой сурвалжлага хийдэг болсон.

Гэхдээ телевизийн мэдээллийн сонголтыг энэ хоёр зарчимтай хослон тодорхойлдог, магадгүй илүү хүчтэй үйлчилдэг, гэхдээ анзаарагдаггүй зарчим бол юуг сурвалжилж мэдээлэхийг дээрээс зааж өгдөг, түүнийг ягштал хэрэгжүүлдэг явдал юм. Тухайн телевизийн захирал, мэдээллийн албаны дарга, редакторууд үүсгэн байгуулагчдийн бодлогод нийцсэн, эсвэл дээрээс шууд зааж өгсөн үйл явдлуудыг сонгож мэдээлэхийг хэлж байна. Төр засгийн алба амьдралыг сурвалжлах арга хэлбэр тун боловсронгуй болжээ. TV5 телевиз гэхэд дарга нарын хэлсэн үгийг өгүүлбэр өгүүлбэрээр тасалж задлан хүргэдэг аргыг үе үе хэрэглэдэг. (...Дарга эхлээд энэ тухай ярив? Хүлээж авч сонсоорой ... Дараа нь юу ярьсан бэ гэвэл... Дарга цааш бас нэгэн чухал асуудлыг хөндлөө. Одоо үүнийг сонсоё.... г.м.) болсон байна.

Төр засгийн мэдээлэл бол улс орны хэмжээний ач холбогдолтой учраас олон нийтэд хэрэгтэй гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ телевизийн мэдээллээс харахад Монгол Улсад зөвхөн төр засаг, эрхэм гишүүд, сайд дарга нар ажил хийдэг юм шиг сэтгэгдэл төрөхөөр болжээ. Зогсоо зайгүй сурталчлаад байгаа хурал, уулзалт, семинар, шийдвэр, тойрогтоо ажиллах, очиж танилцах,

шийдвэр гаргах явдал бол тэртээ тэргүй тэдний хийх ёстой ажил юм. Тэр болгон мэдээллийн шалтаг байх ёсгүй. Ингээд мэдээллийн биш сурталчилгааны хөтөлбөрүүд болон хувирч байна.

10-р сарын эхээр УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж нар Олон улсын парламентийн хуралдаанд оролцоод ирсэн талаар хэдэн өдрийн турш маш том сурталчилгаа хийлээ. Ж.Бямбадорж: ажил хэрэгч хуралдав... гэх мэтээр ярьж бүх сувгаар гарав. Энэ үйл явдал олон нийтэд тийм чухал хэрэгтэй юм уу?

Улс оронд болж байгаа ажил төрөл болгоныг Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй. Улаанбаатарт хийсэн юм болгоныг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын жилтэй холбодог.

2003.10.23. Пүрэв

"Цагийн хүрд"

- "Монгол Улсын Засгийн газраас 2003 оны хоршоолын дэмжих жил болгосны ачаар" хоршооны мэдээллийн төв нээгдэв
- Монгол Улсын засгийн газрын мөрийн хөтөлбөрийн ачаар Ховдын тариаланчдад бага оврын трактор гардуула..

2003.10.20. Лхагва

UBS "City News"

- Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын жилд нийслэлийн хөрөнгөөр 1 сая төгрөгөөр Багануурын нэгэн хэсгийн халуун хүйтэн усны шугамыг сольж дуусав. "Багануур Увс" НӨҮГ-ын даргын яриа.

Эсвэл хоёулантай нь зэрэг холбодог болж байна.

2003.10.22. Лхагва

UBS "City News"

- Өлзийт хороонд өрхийн эмнэлэг барив. "Энэ бол Засгийн газраас хэрэгжүүлж байгаа өрхийн амьжиргааны төслийн хүрээнд хийсэн хөрөнгө оруулалт.... Бүтээн байгуулалтын жилийн томоохон хөрөнгө оруулалт юм...

"Нэг л биш" гэдгээ "Монголын мэдээ" агентлагынхан мэддэг бололтой. .

2003.10.18. Бямба

"Цагийн хүрд"

- Сурв: Сүүлийн үед гадаад дотоодын хөрөнгө мөнгөөр чамин нэр хаягтай олон төсөл хэрэгжиж, энд тэндгүй сургалт семинар зохиогддог болсон. Харамсалтай нь тэдгээр сургалтууд чухам хэнд хэрэгтэй байдаг нь эргэлзээтэй. Уг нь дээрх төсөл хөтөлбөрүүд хүн төрөлхтөний сайн сайхныг бэлэгдсэн их л чамин нэр устай байдаг. Өсвөр үеийн боловсрол эрүүл мэнд, зайны сургалтаар дамжуулан соён гэгээрүүлье, эцэг эхчүүд хүүхдээ ойлгож дэмжихэд нь туслах хөтөлбөр гэх мэт олон арван нэрийг энд дурдаж болно. Эдгээр нэрүүдийг сонсоод байхад аль хэдийнэ манай хүүхэд залуус бүх талын өв тэгш хмүүжилтэй болчихсон баймаар. Гэтэл өнөөдөр энэ бүгдээс гарсан үр дүн даанч баа байгаа юм....Шалтгаан олон.. Хүүхэд залуучууд ихэд хэнэггүй болсон... Нөгөө талаар төсөл хэрэгжүүлдэг мундаг нөхдүүд хурал семинар дамжин гүйлдэж нөгөө хөрөнгө мөнгийн барж орхиодог гээд хэлчихэд нэг их буруудахгүй болов уу. Энэ мэтээс болоод олон арван билэгдлийн чанартай сургалт, хөтөлбөрүүд үр дүн багатай өнгөрч байна. Харин одоо өсвөр үеийнхний аж байдлыг сайжруулах нь нэртэй нэгэн төслийн талаар товч танилцуулья. Энэ төсөл нь мөн л дээрхийн нэгэн адил хүүхдийн сайн сайхны төлөө гэсэн уриатай юм. Төслийн ажилтны яриа: Зайны сургалтын хэлбэрээр өгч байна. Энд байгаа сургалтын материалуудыг боловсруулж өгдөг. Бие даан суралцах материал гэсэн үг. Дээрээс нь радио хичээл, сургалтын хичээл, сургалтын төв дээрх цугларалт ...
- Сурв: Зарим тохиолдолд ямарваа нэг төсөл юм уу хөтөлбөр гэхлээр өнгө будаг алагласан ном хэвлээд л дуусаа. Тэдгээр номуудыг хөдөө орон нутагт тараачихаад төсөл амжилттай

хэрэгжлээ гэж ярих ч тохиолдол бий. Гэтэл яг газар дээрээ хүүхдүүдэд энэ талын мэдээллийг яаж өгөх вэ гэдгийг орхигдуулаад байх шиг.... Албан бус боловсролыг хүүхдүүдэд олгоход арай шинэлэг арга замыг сэтгэхгүй бол үр дүнгүй шахам олон төслүүд хэрэгжээд хэрэгжээд ашиггүй байгаа юм.

2003.11.20:

- Хэнтийн Өмнөдэлгэр сумын барилгыг засварлан хүлээлгэн өгөв. УИХ-ын гишүүн Ганбямба, ЭМЯ-ын газрын дарга нар тууз хайчилж байна. Харин хэрэгжсэн хэрэгжээгүй нь мэдэгдэхгүй олон төслүүдээс ялгаж харуулахын тулд энэ төслийн тухай танилцуулья.

20.00. "Цагийн хүрд"

- УИХ-ын намрын чуулганы нээлтийн тухай сурвалжлага дэлгэрэнгүй тайлбартай байлаа. Жишээлбэл: "... үг хэлье хэмээн орилж хашгичиж байгаа нь дээрх хууль зөрчсөн хэрэг болох юм... Засгийн газрын тэргүүний үгийг ард түмэндээ хүргэх үед нь санаатайгаар гэж хэлж болохоор 3 удаа саад хийж байгаа... Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлт сайн байгаа нь сөрөг хүчнийхнийг ийм зохисгүй үйлдэл хийхэд хүргэж байна гэсэн үзэл бодолтой хүн ч байна. "
- Дараа нь сонсогчдын санал бодлыг нэвтрүүллээ. 7 хүн ярьснаас 6 нь Гүндалайн буруу гэсэн байр суурийг илэрхийлж зөвхөн нэг залуу: "Би ардчилсан намын дэмждэг л дээ. Хууль эрхийн талаасаа буруу л даа. Гэхдээ өөрөө тэгэхээс өөр аргагүй юм шиг санагдаад байна..." гэв. Энэ бол сүүлийн жилүүдэд улс төрийн маргаантай асуудлаар сөрөг байр суурийг илэрхийлснийг оруулсан анхны тохиолдол байлаа.

Бид цорын ганц сөрөг байр суурийг нэвтрүүлсэнд баярладаг болжээ.

2003.10.15. Лхагва

МҮТВ. "Цагийн хүрд"

- Улсын мэргэжлийн хяналтын газраас Төв аймагт шалгалт хийж дууслаа.... УМХГ-ын ажилтны яриа: сайн дүн үзүүллээ

Сурвалжлагч: Алтны уурхай олонтой, байгаль орчныг нөхөн сэргээлт хаа сайгүй хангалтгүй байхад Төв аймагт байгаль орчны хууль тогтоомжийн биелэлт сайн байна гэж дүгнэсэн нь юу л бол хачирхалтай.

Д.Ц: Энэ бол сүүлийн үед Монгол телевизийн төрийн агентлагийн ажлыг бага ч гэсэн шүүмжилсэн анхны тохиолдол юм.

Энэ 10-р сарын эхнээс өнөөдрийг хүртэл Монголд тохиолдсон үйл явдлууд, тэдгээрээс хамгийн өргөн олон нийтэд хамаатай асуудлууд телевизийн дэлгэцнээ хэрхэн тусгалаа олов?

Олон нийтийн ач холбогдолтой хэд хэдэн үйл явдлыг телевизүүд сайн тусгагдлаа. Тухайлбал,

- Шатахууны үнэ өссөны тоо баримт, шалтгаан
- Талхны үнэ өссөн, шалтгаан, "Өгөөж" компани үнээ өсгөөгүй тухай...
- УИХ-аас хэлэлцэж буй замын хөдөлгөөнийх хууль тогтоомжинд өөрчлөлт оруулах, зөвшөөрөлгүй газар тавьсан машиныг журамлаж тээвэрлэх тухай гэх мэт

Нөгөө талаар бид мэдээллийг зөвхөн телевизээс авдаггүй. Телевизээр гараагүй үйл явдлыг бас сонин хэвлэлээс мэдэж болно. Өнөөдөр хамгийн их гомдоллодог сөрөг хүчний байр суурийг хүсвэл хаа нэгтгээгээс, тухайлбал, орон нутагтүзэж сонсож чадахгүй юм аа гэхэд уншиж болно. Сонин хэвлэлээр дүүрэн сөрөг хүчнийхний ярилцлага. Тэр ч бүү хэл эрх баригчдын гарт чанга атгаастай байгаа МҮТВ-ээр хүртэл сөрөг хүчний нэвтрүүлэг хааяа ч гэсэн, оргил цагаас дэндүү эрт буюу 18 цаг өнгөрөөгөөд ч гэсэн явдаг. Гэхдээ Монголын үндэсний

телевиз нэгдүгээрт, хамгийн хүртээмжтэй, хоёрдугаарт, орон нутагт бараг цорын ганц (радио эс тооцвол) мэдээллийн хэрэгсэл учраас өнөөгийн төр засгийн зогсоо зайгүй сурталчилгаа тэвчишгүй болжээ.

2003.10.22. Лхагва

"Ёс ёмбогор, төр төмбөгөр бус уу..." нэвтрүүлэг.

УИХ-ын гишүүн Болормаагийн яриа: Нямдорж сайдыг гүтгэснийг шүүх, прокурор зүгээр өнгөрүүлсэн.... Нямдорж сайд ялах ёстой...

УИХ-ын гишүүн Баттулгын яриа.

Нэвтрүүлэгч: Гүндалай гэж хэн бэ?... Гурван төрлийн бизнес эрхэлж байсан. Спиртийн наймаа хийж байсан ... Архины үйлдвэрлэл эрхэлдэг байсан.... 10 сая төгрөг хожоорой гэж байж ард түмнээ цэвэр араар нь тавьсан... "Тэжүүжин" үг бүрдүүлж 10 сая төгрөг хожсон хүн байгаагүй...Нүцгэн охидыг бүжиглүүлж байсан ... 2000 онд танай намаас нэр дэвсье гэж талийгаач Энэбишд хүргэн ах Гүндалайгаар дамжуулан гуйсан...

УИХ-ын чуулганы нээлтэнд дээрх Гүндалайн үйлдлийн талаар хүмүүсийн санал бодлыг сонсголоо. Урьд "Нээлттэй микрофон"-оор гарч байсан саналууд...

УИХ-ын гишүүн Баттулгын яриа:

УИХ-ын гишүүн Болормаагийн яриа:

Нэвтрүүлэгч: Ардчилсан намын "алиа салбадай" Л.Гүндалай ... нийтдээ 750 сая төгрөгийн татвараас зугатсан.... 180 мянган долларыг Киприйн компанид өгөх ёстой ч өгөөгүй "хоёр чихнээс өөр өгөх юмгүй" гэжээ ... Сонгуульд "ёстой л хоёр чихээ зарж" ... Хуучин эхнэр, хоёр хүүхдээ Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар харьяатаас гаргаж Германы иргэн болгосон...

... Ёс ёмбогор, төр төмбөгөр бус уу, Төр түмэн нүдтэй"

Ямар ч нэр, хаяг байсангүй. Зөвхөн "2003 он" гэжээ.

Нэвтрүүлгээс үзэхэд Гүндалай их муу хүн юм байна. Гэхдээ энэ тухайд нэр нүүрээ нуусан, ямар ч хаяггүй нэвтрүүлэг сэмхэн оруулж байгаа нь дутуугүй муухай. Одоо энэ нэвтрүүлэг хэдхэн хоногийн дараа UBS-ээр сэмхэн гарна.

Улаанбаатарт хэвлэгдэн гарч байгаа тэр олон сонинуудаас уншихгүй, зөвхөн Монголын үндэсний телевизийг үзэж суугаа хөдөөгийн үзэгчдийн тархийг үнэхээр угааж байна гэж хэлэхээс өөр аргагүй.

Сүүлийн өдрүүдэд МУТВ зарим үйл явдлуудыг "харалгүй" өнгөрөөлөө. Жишээлбэл, менежментийн хувьчлалын дараах "Автобус-3" компанийг тойрсон үйл явдлууд

Улаанбаатарын иргэдэд мэдээлэл тоо хэмжээний хувьд хангалттай. Сонин хэвлэлийн хэдэн зуун нэр төрөл, телевиз радиогийн хэдэн арван суваг, нэвтрүүлгийн цагийг тооцоолбол уншиж, үзэж барахааргүй их. 2003 онд гэхэд дахиад 2 телевиз нэмэгдлээ. Тэр хэмжээгээр мэдээлэл нэмэгдэж сонголт өргөжлөө. Ихэнхдээ нөгөө л үйл явдлуудыг зэрэгцэн сурвалжилж үзүүлдэг боловч заримдаа шинэ сэдэв, үйл явдал, асуудлыг олж хардаг. Хамгийн гол нь өрсөлдөөн нэмэгдэж байна. Улаанбаатарт байгаа та бидний хувьд нэг нь таалагдахгүй бол сувгаа солиод өөр таалагдсан мэдээллийг авч болно.

Гэхдээ олон нийтийн өргөн нэвтрүүлэг гэсэн шалгуураар авч үзвэл тийм телевиз манайд алга аа. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг гэхлээр юуны түрүүнд хэвлэлийн эрх чөлөөг гаргаж ирдэг. Тэгвэл сөрөг хүчний байр суурийг нэвтрүүлээд, эсвэл Энхбаяр, Энхсайхан хоёрыг зэрэгцүүлж суулгаад, тэр хоёрыг минут секундын зөрөөгүй тэнцүү яриулдаг болчихвол олон нийтийн нэвтрүүлэг болчих уу? Эсвэл төр засгийн болон улс төрийн мэдээллийг багасгаад захын хороолоор очоод жирийн амьдралыг харуулаад байвал болчих

юм уу? Ямар ч байсан улс оронд өрнөж буй үйл явдал, асуудалд (түүний дотор улс төрийн хүчнүүдэд) манай телевизүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хувьд (хэрвээ үзэл суртлын дайчин зэвсэг энэ тэр биш л юм бол) сэтгүүл зүйн зарчмаар хандах цаг болжээ. Өөрөөр хэлбэл, төр засагт биш, гэхдээ сөрөг хүчинд биш, бас эзэддээ биш, гэхдээ өөрсөддөө биш, юуны түрүүнд үзэгчиддээ үйлчлэхийг хэлж байна. Үзэгчид гэдгийн цаана олон нийт, олон нийтийн эрх ашиг байгаа.

Тэгвэл олон нийтийн эрх ашиг гэж юу вэ? Ямар сэдвийг, эсвэл яаж тусгасныг олон нийтийн ашиг сонирхолд нийцсэнд тооцох вэ? Үүнийг хэрхэн томъёолох вэ? Цаашилбал, телевиз олон нийтийн болчихвол ямар өөрчлөлт гарах бол? Ерөөсөө олон нийтийн телевиз ямар байх ёстой вэ?

Маш энгийн байдлаар авч үзье. Олон нийтийн эрх ашигт нийцнэ гэдэг бол 1. Сонголтой байх. 2. Бие даасан байр сууринаас тайлбарладаг, анализ, дүн шинжилгээ хийдэг байх 3. Олон янзын үзэл бодол, маргаан, хэлэлцүүлэг өрнүүлдэг байх.

2003 онд Монголд дахиад хоёр телевиз гарч ирлээ. Дээр дурдсанчлан зарим нэг шинэ нэвтрүүлэг нэмэгдсэн, заримдаа дахиад хэдэн сонирхолтой сурвалжлага үзүүлдэг болсон ч миний хувьд үндсэндээ зөвхөн тооны өсөлтийг олж харж байна. Бусад телевизүүдэд нэгэнт байгаа нэвтрүүлгүүдийн ээлжит хувилбар (клон)-ууд олноор нэмэгдлээ. Хамгийн гол нь мэдээллийн хөтөлбөрт зарчмын өөрчлөлт гараагүй. "Ийгл"-ийн мэдээллийг аль нь ч нөхөж чадаагүй. Аливаа телевизийн нүүр царай, таних тэмдэг нь мэдээллийн хөтөлбөр. Гэтэл нөгөө л төр засгийн үйл явдлыг тойрсон сурвалжлагууд.

- УИХ-ын намрын чуулган нээгдээд 2003 оны Монгол улсын төсвийн төслийг хэлэлцэж байна. Энэ бол маш чухал үйл явдал. Энэ тухай сурвалжлагыг бүх телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр үзүүлж байна. Гэвч эрхэм гишүүд нэг нэгээрээ үг хэлж тойрогтоо мөнгө нэхэж буйн зах зухаас харуулаад гүйцээ. Тэр олон тоонууд ямар учиртай юм бэ? Өмнөх жилийн төслийн хэрхэн гүйцэтгэсэн бэ? Ийм яриа хөөрөө өрнүүлэх гэсэн оролдлогыг аль ч телевизээр хийгээгүй байна.

Тэгвэл нийгмийн амьдралын үйл явдлуудыг хэрхэн тусгаж байна вэ? Монголын телевизүүд жирийн ард иргэдийн амьдралыг зөвхөн төрийн засгийн ажил албаны цаад фон гэж үздэг нь хэвээрээ Тайлбарлая. Телевизийн сурвалжлагчид зөвхөн эрхэм гишүүд, дарга сайд нарыг дагаж хотын зах руу очдог гэвэл нэг их хэтрүүлэг болохгүй биз. Хөдөөний амьдрал? Бас л дарга нарыг, эсвэл элдэв төслийнхөн, заримдаа хяналт шалгалтынхныг дагаж хөдөөлдөг. Сүүлийн үед эрхэм гишүүн болон сайд дарга наргүйгээр, эсвэл найр наадам сурвалжлагаас өөрөөр хөдөө явсан телевизийн нэг ч сурвалжлах хэсгийг би санахгүй байна.

Сүүлийн өдрүүдэд та бид орон нутгаас хийсэн сурвалжлагуудыг үзэхгүй байна. Яагаад гэвэл Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга хоёр Шведэд яваа, Ерөнхийлөгч, УИХ-ын дарга орон нутагт томилолтоор яваагүй.

Бас нэг зүйл. Манай телевизүүдэд реклам сурталчилгаа буюу бизнесийн хүчин зүйл буюу шийдвэрлэх нөлөөтэй болжээ. Телевизийн ихэнх сэтгүүлчид тодорхой компанийн юмуу бараа үйлчилгээний зар сурталчилгааны менежерүүд

шиг ажилладаг. Манай телевизүүд "үндэсний", "хувийн чөлөөт" гэх мэт дуудлагатай боловч үнэн хэрэгтээ аль хэдийнэ арилжааны шинжтэй телевизүүд болж хувирсан. Зах зээлд хэвлэл мэдээлэл оршин тогтох үндэс нь реклам сурталчилгаа гэдэг нь ойлгомжтой, гэхдээ манай телевизүүдийн, ялангуяа зарим нэвтрүүлгийн арилжааны шинж чанар сэтгэл түгшээх хэмжээнд хүрлээ. Мөнгө өгвөл эрх чөлөөтэй байхаас ч буцахгүй. Мөнгө өгвөл сөрөг хүчнийг ч яриулна, төр засгийг ч шүүмжилнэ. Ийм телевизийн нэвтрүүлэг олон нийтийн эрх ашигт хэр нийцэх вэ?

Рекламууд багтаж ядаж байна. Мөнгө авч хийсэн нэвтрүүлгүүдийг нуудаг гоё нэр хаяг өгдөг болсон. "Үндэсний компаниудыг дэмжих цаг" (TV9), "2003-Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын жил" (UBS)-ийн цаана сурталчилгааны нэвтрүүлэг байх жишээтэй.

2003.10.13. Даваа

"25-р суваг" телевиз. "Сонины нийтлэлийн мөрөөр" нэвтрүүлэг.

Ямар ч эхлэл, тайлбар байсангүй.

Сэтгүүлч Х.Өлзийбаяр өөр камер харж байгаад яриагаа эхлэв.

"Миний гарт "Өдрийн сонин"-ы энэ оны 9-р сарын 23-ны өдрийн дугаар байна. Энэ сонин 10-р нүүрт "Их өр гэгчийнхээ оронд газар нутгаасаа өгөөд байна уу?" нэртэй өгүүлэл нийтлэгджээ. За, энэ өгүүлэл юуны тухай өгүүлсэн бэ? Юутай ч гэсэн энэ өгүүлэл төгсөхдөө "энэ сарын 25-ны өдөр Төв аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаан болно. Энэ хуралдаанаар ямар шийдвэр гарснаас Заамар сумын гэдэг газрын хувь заяа шийдэгдэнэ" гэж төгссөн байна. Тэхээр Төв аймгийн ИТХ-ийн хуралдаан ямар тухай асуудлыг хэлэлцэж ямар шийдвэр гаргасан бэ?

Бичлэг: ...

Төв аймгийн ИТХ-ийн хуралдаан өнөөдөр монголчуудын бараг шүдний өвчин гэмээр болоод байгаа Заамар сумын нутагт алт олборлож байгаа аж ахуйн нэгж болоод хулгайгаар алт олборлодог "нинжа" нарын тухай хэлэлцсэн юм. Гэтэл хурлаас ямар нэгэн шийдвэр гарах нь тодорхойгүй байтал ингээд сонин хэвлэлээр ийнхүү шуугиад эхэлсэн юм асуудлыг нэлээд өргөн хүрээтэй хэлэлцэх шаардлагыг бий болгосон байна. Хуралдаанд аймгийн Засаг дарга Мэндбилэг Заамар сумын нутаг дахь аймгийн тусгай хамгаалалтай зарим газар нутгийг тусгай хамгаалалтаас гаргах тухай асуудлыг оруулж хэлэлцүүлээ.

М.Мэндчилэг:аймгийн Засаг даргын зөвлөл хуралдаад ... хууль ёсны, мэргэжлийн, чадалтай компаниудад алттай газруудыг гэрээгээр ... эзэмшүүлбэл ... гэж ярьсан.

Заамар сумын иргэн: ... аль ч талд өгүүлэхгүй байгаасай.... энд манай хамаг бэлчээр байгаа....

Сурв: тодорхой шийдвэр гаргасангүй....Сумын ИТХ-ын төлөөлөгчид хуралдсан боловч тодорхой шийдвэр гаргаагүй.... асуудлыг хоёр өөр янзаар ярьж байна.... Гэхдээ газар дээрээ байдал ямар байна вэ?

Алт олборлогч иргэд хэрхэн ажиллаж байгаа тухай сурвалжлага, тэдний яриа, засаг даргын Д.Болдын яриа.

Д.Ц. Энэ нэвтрүүлгийн зорилго үүнээс хойш тодорхой боллоо

Засаг дарга Мэндбилэг: ... зарим хөрөнгө оруулагчийг дэмжих нь чухал байгаа юм.... "Алтан Дорнод" компанийг онцолж үздэг юм байна лээ... Энэ компани чинь уул уурхайн салбараасаа гадна хөрөнгө оруулж эхэлж байгаа... Би тийм тийм гэж хэлэх, шийддэг тийм эрх мэдлийн хүн биш, зүгээр миний албаны шугамаар авсан мэдээллээр бол энэ компанийг дагаад манайд ГАЗ машиныг угсрах үйлдвэр Улаанбаатарын орчим байгуулагдах юм шиг байгаа юм. ...гар хөлийн үсэг зурагдах ёстой юм шиг байгаа юм...Тийм учраас би үндэсний үзэл бодол ч гэдэг юм уу, тийм талаасаа дэмжиж байгаа юм.

Заамар суманд алт олборлож байгаа компаниудаас хамгийн том нь Оросын 100 хувийн хөрөнгө оруулалттай "Алтан дорнод-Монгол" компани юм байна. Тэгээд ч тэр үү дээрх газруудыг тусгай хамгаалалтаас гаргачих юм бол хайгууль хийх зөвшөөрөл авахаар хүсэлтээ гаргажээ.

"Алтан Дорнод" компанийн монгол талын захирал Ж.Товуудоржийн яриа: Сурв: ... Заамар сум өнөөдөр Монголын Эльдарода болоод байна... Өнөөдөр хулгайгаар алт олборлогчид ... тусгай хамгаалалтай газар луу орчихсон байхыг та бүхэн сая үзлээ. Тэгэхлээр хулгайгаар алт олборлогчдод байгалаа сүйтгүүлээд төсөвтөө ганц ч төгрөг авч чадахгүй байх уу?...

Төгсгөлд нь ердөө л "2003 он".

2003.10.14. Мягмар

Дахин хоёр телевизээр нэвтэрлээ.

"TV5" телевиз. 20.30. (Оргил цаг)

"Сонины нийтлэлийн мөрөөр" нэртэй

Эхлэл төгсгөлд ямар ч тайлбар үгүй.

TV9. 21.35. (Оргил цаг)

"Захиалгат нэвтрүүлэг" нэртэй

Эхлэл төгсгөлд ямар ч тайлбар үгүй.

Дээр дурдсан улс төрийн (тухайн телевизийн эзэмшил, харьяаллаас үүдсэн) ба бизнесийн (оршин тогтнох, ашиг олох шаардлагаас үүдсэн) шалтгааны улмаас бид маш олон үйл явдлыг телевизийн дэлгэцнээс огт үзээгүй өнгөрөөжээ.

Хоёрхон жишээ:

"АПУ" ХК-ийн хуучин захирал Жамьянсүрэн нарт эрүүгийн хэрэг үүсгэснийг телевизүүд огт нэвтрүүлээгүй.

- 10-р сарын 17 Дэлхий даяар ядууралтай тэмцэх өдөр байжээ. Бид мэдээгүй өнгөрсөн. Яагаад ч юм төр засгаас томоор тэмдэглэж арга хэмжээ зохион байгуулахгүйгээр шийдсэн.
- Японы засгийн газрын буцалтгүй тусламж хэрхэн хэрэгжиж байгааг үзэхээр Японы иргэний хяналтын Ямада тэргүүтэй төлөөлөгчид Монголд ажиллаж байна. Үүнийг манай хэвлэл мэдээллийнхэн орж харж сурвалжлав уу.

Сайндаа л хагас дутуу мэдээлэхээс хэтэрдэггүй. Ажиглаад байхад, сонин хэвлэлүүд радио, телевизийг бодвол асуудал үйл явдлыг илүү гүнзгий тусгаж чадаж байгааг энд хэлье.

Зарим асуудал руу монголын телевизүүд хэзээ ч гүнзгий орохгүй, "дурдаад өнгөрөхөөс" хэтрэхгүй. Сүүлийн жилүүдэд олон нийтийн эрх ашгийг хамгийн ноцтой хөндсөн асуудал бол Улаанбаатар хотод орон сууцны барилгуудын дунд барилга барих зөвшөөрөл олгосныг оршин суугчдийн зүгээс эсэргүүцсэн "газрын маргаан" юм. Телевизүүд сенсаац мэдээ буюу "зодоон боллоо" гэсэн утгаар мэдээлээд орхидог. Газрын маргаан гараад байгаагийн цаад учир шалтгаан - газрын зөвшөөрөл олгодог механизмыг манай хэвлэл мэдээлэл хэзээ ч ил тод болгож байгаагүй. Шалтгаан тодорхой....

Чухам иймэрхүү эгзэгтэй үйл явдлууд ба асуудлаар телевизүүд үнэн нүүр царайгаа харуулдаг.

Нийслэлд шилжиж ирсэн орон нутгийн иргэдээс хураамж авдаг журам хэдэн жилийн турш үйлчлээд Хүний эрхийн үндэсний комиссын шахалт шаардлагаар шүүхэд хүрч 2003 оны 7-р сарын 1-нээс цуцлагдсан, Улаанбаатар хотын ЗДТГ дээд шүүхэд давж заалдаад 9-р сар гартал үргэлжлүүлэн авсан билээ. Энэ бол олон нийтийн эрх ашгийг хөндсөн маш том асуудал. Үүнийг сонин хэвлэлүүд шүүмжилж янз бүрээр бичиж байсан, гэтэл телевизүүд хааяа нэг дурдсан, шууд ярилцлагын асуулт хариултаар хөндөгдсөн ганц нэгхэн тохиолдлыг эс тооцвол огт анзаардаггүй байсан. Асуудал шийдэгдсэний дараа буцаад хураамжтэй болох нь гэсэн цуу яриа гарч 9-р сарын сүүлч, 10-р сарын эхээр ЗДТГ-ын ард ямар их оочир дараалал үүссэнийг бид мэдэж байлаа. Яах аргагүй сенсаац үйл явдал учраас "25-р суваг", "TV9" очиж сурвалжилсан. Ялангуяа "25-р суваг" суваг хэдэнтээ хурцаар шүүмжиллээ. Гэтэл нийслэлийн "олон нийтийн телевиз"

болох UBS шилжин ирэгсдийг янз бүрээр муутгасан, илт дайсагнасан сурталчилгаагаа үргэлжлүүлсээр байна. Бас хэдэн зуун хүн (тэдний ард мянга мянган хүн байгаа) өдөр шөнөгүй оочирлож байхад МУТВ огт "мэдээгүй" өнгөрч байгаа юм даа. Одоо ч иргэдийн эрхийг хязгаарлах өөр арга олсон. Зөвхөн ажлын байраа олсон хүмүүст шилжүүлэг хийж өгөх юм гэнэ. Хэрвээ хөдөөнөөс ирсэн тэр нөхөр англи хэлтэй, 25-аас доош настай, царайлаг биш бол Улаанбаатараас ажлын байр олооч.... "Үндэсний телевиз", "олон нийтийн телевиз", "чөлөөт телевиз", "таны телевиз"-үүд хаана байна?

Энд байна.

2003.10.07. Мягмар

UBS. "Сити ньюс"

- Хотын иргэд болох хүсэлтэй хүмүүс сүүлийн өдрүүдэд оочирлож байгаа тухай тайлбар. УБ хотын ЗДТГ-ын дарга Д.Болдсайхантай ярилцлага. Сурвалжлагчийн дүгнэлтын гол санаа: Хотын дэд бүтэц хүндэрч байна.

2003.10.10. Баасан

"Цагийн хүрд"

- Улаанбаатар хот руу чиглэсэн нүүдлийн тухай. тайлбар: ...Иргэд шилжүүлгээ зохих ёсоор хийдэггүй Нийслэл 1 сая хүнтэй болоод байна... Хэдийгээр хүн дуртай газраа амьдрах эрхтэй боловч дуртай газраа хашаа хатгаж байна....

2003.10.11. Бямба

"Цагийн хүрд"

- "Улаанбаатарыг чиглэсэн их нүүдэл жилээс жилд нэмэгдсээр өнөөдөр нийслэлийн дөрвөн дүүргийн гэр хорооллын хүн ам эрс өсөөд байна. Хөдөө орон нутгаас жилд 25-30 мянган хүн нийслэлд шилжин ирдэг гэсэн тооцоо байна. Харин шилжин ирж суурьшиж ирж байгаа иргэд маань шилжилт хөдөлгөөнөө зохих ёсоор хийдэггүйгээс тухайн хорооноос ямар нэг ажил зохиоход хүндрэлтэй байна. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12-р хорооны засаг даргын яриа: "Хотод орж суурьшиж байгаа улсуудын ихэнх нь бараг л манай хороогоор дамждаг юу уу гэмээр байдаг. Яагаад гэвэл нэгдүгээрт мал хуйтай учраас эхлээд захын хороонд ирдэг. Тэгээд дараа нь шилжилт хөдөлгөөнийхөө асуудлаа хөөцөлддөг. Манай хороонд гэхэд 30 гаруй өрх байгаа". 2000 оны хүн амын тооллогоор Улаанбаатар хот 870 гаруй мянган хүн амтай байсан бол энэ тоо өнөөдөр сая гаруйд бараг хүрчихээд байгаа. Нийслэлд шилжин ирэгсэд урьд нь хураамж төлдөг байсныг энэ сарын нэгнээс хүчингүй болгох шийдвэр гаргасан. Хэдийгээр хүн хүссэн газраа амьдарч ажиллах эрхтэй боловч дуртай газраа хашаа хатган суурьшдагаас өнөөдөр нийслэлийн зах хорооллын дэд бүтэц, ахуйн үйлчилгээ зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд амаргүй болоод байна.

"25-р суваг" телевиз

"Цонх" нэвтрүүлэг.

Улаанбаатарыг зүглэсэн их нүүдлийн тухай эрэгцүүлэл. "Хот дотроо шаваралдаад нүүдэл суудлын буян харагдахгүй байна ... Хөөрхий Улаанбаатар хашаагаа даахгүй..."

2003.10.22. Лхагва

TV5. Мэдээллийн хөтөлбөр

- Өнгөрсөн хэд хоногт Улаанбаатарт шилжиж ирэх гэсэн иргэд ЗДТГ-т оочирлоод материалаа ч өгч чадахгүй байна. ЗДТГ-ын шилжилт хөдөлгөөн хариуцсан ажилтан: оператортойгоо нийлээд хоёулаа өдөр 100 өргөдөл хүлээж авч байна. Оочирлож байгаа эмэгтэй: Би Говь-Алтайгаас найман жилийн өмнө ирсэн.... Би жирэмсэн, энд оочирлоод хоёр хонож байна, одоо хүртэл орж ирээгүй... Ажилд орсон байгууллагынхаа боловсон хүчнээ дагуулж ир гэж байна...

Улаанбаатар луу чиглэсэн их нүүдэл бол үнэхээр амаргүй асуудал. Телевиз яах ёстой юм бэ? Нэгдүгээрт, бодит байдлыг харуулах ёстой. Хоёрдугаарт

Энэ бол янз бүрийн байр суурь, хэлэлцүүлэг, маргаан ... Өнөөдөр монголын телевизүүдэд дутагдаж байгаа ганц юм бол энэ. 1990-ээд оны эхний жилүүдтэй харьцуулахад МҮТВ олон ургальч үзлийн индэр байхаа больж ухралт хийжээ. Үүний оронд чухал асуудлыг хэн нэгэн албан тушаалтан, сайд даргаар, хэрвээ тийм биш бол адил байр суурьтай, "дэмждэг" хүмүүсээр тайлбарлуулдаг.

"Студи-600"-гаар нэг даргыг бүхэл бүтэн 40 минут яриулж Монгол орон даяар хэдэн зуун мянган айл өрхийн хоймрыг эзлүүлдэг. Энэ бол 4-5 хүнийг нуршихгүйгээр яриулахад хангалттай хугацаа.

2003.10.20. "Нээлттэй микрофон"

... "Бид "Нээлттэй микрофон" нэвтрүүлгээрээ микрофоноо үзэгч та бүхний дунд аялуулж санал бодлыг тань нээлттэйгээр телевиз үзэгчиддээ хүргэдэг байсан бол өнөөдрөөс эхлэн зарим дугаартаа сэтгүүлч, нийтлэлч, зохиолчдыг урьж оролцуулан нийгмийн аливаа асуудлаархи тэдний санал бодол, үзлийг нээлттэйгээр мөн толилуулж байх болно. Ингээд бидний өнөөдрийн хөндөж байгаа сэдэв бол "Үдшийн галын дэргэд". Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, ахмад сэтгүүлч Амбасэлмаа оролцож дурсамжаасаа ярив.

Олон нийтэд нэмэлт мэдээлэл өгөх, тодруулах, эрэн сурвалжилдаггүй юм аа гэхэд очоод сурвалжлах олон үйл явдлыг телевизүүд өнгөрөөсөн.

Жишээ:

- Саяхан Гаалийн байгууллагад ажиллаж байгаад архи уугаад, бас зодуулаад халагдсан залуугийн ээж өлсгөлөн зарласан. ГЕГ-д дарга Баатарын хэвлэлийн бага хурал. Х.БаатарҮрхичинг буцааж авахгүй... Залууг буцаагаад ажилд авсан....

Жирийн хүмүүсийн эрх ашгийг шууд хөндсөн шийдвэр гаргахаас өмнө хэлэлцүүлэх явдал бүрэн орхигдсон.

- Энэ өдрүүдэд замын хөдөлгөөний хууль тогтоомжинд өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-аар хэлэлцжээ. Анхаарал татсан асуудал бол зориулалтын бус газарт тавьсан машиныг ачаалж зогсоолд аваачиж тавина. Үүнийг хувийн компаниар хийлгэх болж байна. Хамгийн хачирхалтай нь "ийм компаниуд бэлэн, гэрээ хэлэлцээр байгуулсан" гэх утгаар ярьж байх юм.
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн анхны хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо хийлээ. Бусад байнгын хороодын хуралдаан. ("Цагийн хүрд"-ийн сурвалжлага: Нэг иргэн нэг байгууллагад хандан 78 удаа өргөдөл гаргасан тохиолдол бий ... гэж эхлэв).

Гэтэл үүнийг огт хэлэлцээгүй. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэлэлцүүлээгүйн нэгэн адил. Асуудал болгоноор олон түмнийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулдаггүй, санал асуулга явуулдаггүй, ч тухайн тохиолдолд авто машин эзэмшигчид, жолооч нарын байр суурийг илэрхийлж чадах хүмүүсийн байр суурийг ил гаргах, танилцуулах, маргалдуулах нь хэвлэл мэдээллийн, тэгэх тусмаа телевизийн үүрэг.

Манайд улс орны амьдралын амин чухал асуудлаар нийгмийн өргөн хүрээтэй маргаан алга. Улс төрийн хүчнүүдийн мэтгэлцээн, улс төрийн зорилготой сурталчилгаанууд бол байна, харин түүнээс илүү өргөн олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг алга. Хэрвээ сонин хэвлэлийн хуудас дэлгэрэнгүй тайлбар, мэргэжлийн дүн шинжилгээ хийхэд тохиромжтой байдаг бол телевизийн дэлгэц нь хэлэлцүүлэг маргаан өрнүүлж нийт иргэдэд шууд хүргэх хосгүй боломжийг олгодог мэдээллийн хэрэгсэл юм. Харамсалтай нь манай телевизүүд тийм

байж чаддаггүй.

Үнэн хэрэгтээ олон нийтийн өргөн нэвтрүүлгийг бий болгох асуудлыг шийдвэрлэхэд хэцүү биш санагдаж байна. УИХ-аас нэг л өдөр хууль гаргаад өөрчлөн зохион байгуулчихна. Гол хүндрэл олон нийтэд өөрт нь байна. Өөрөөр хэлбэл олон нийт өөрөө "олон нийтийн телевиз"-дээ нөлөөлөх арга механизм олдоогүй байна.

Өнөөдөр ядахдаа олон нийтийн хамгийн идэвхтэй, зохион байгуулагдсан хэсэг болсон төрийн бус байгууллагууд телевизэд нөлөөлж чадаж байгаа юу? Товчоор хэлэхэд, хэрэгжүүлсэн төслийнхөө мөнгөнөөс телевизэд төлж олон нийтийн гэж хэлж болох асуудлаар нэвтрүүлгээ явуулдаг болжээ....

2003.10.13. Даваа

МҮТВ. "Нээлттэй микрофон"

Иргэдийн үгийг сонсгодог цорын ганц нэвтрүүлэг гэж ойлгогддог. Гэтэл:

"Тахир дутуу иргэдийн асуудал төр засгийн байнгын анхаарлын төвд байдаг ... 2001 оныг тахир дутуу иргэдийн жил болгосон.... Тахир дутуу иргэдийн талаар зохицуулах үүргийг МТДИҮХ гүйцэтгэдэг. Үүнийг тайлбарлах зорилгоор энэ удаагийн нэвтрүүлгийг бэлтгэв.

МТДИҮХ-ны тэргүүлэгч Ц.Оюунбаатар: "... Ганди гишүүн энэ холбоог авснаар их хурлын гишүүнээр дамжуулан ажиллаж"

УИХ-ын гишүүн Т.Ганди (МТДИҮХ-ны ерөнхийлөгч) "...энэ холбоо дүрмэндээ ерөнхийлөгч нь УИХ-ын нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байна гэж оруулчихсан ... эхэндээ нэлээд хойрго хүлээж авсан... олон удаа уулзаж зөвлөлдөж байж хүлээж авсан....

Ц.Оюунбаатар: ... Гучин хэдэн байгууллага байсныг цэгцэлэе гээд цомхотгох ажил хийсэн....

Т.Ганди: Тахир дутуу хүмүүс эрх ашгаа хамгаалахад хэцүү, эрүүл хүмүүс удирдаж ажиллах хэрэгтэй....

"Хат" нийгэмлэгийн тэргүүн С.Ганболд: ... нэлээд ажил зохиолоо...

Ц.Оюунбаатар: ... амьдралыг нь сайжруулах гээд мөнгө өгөөд байдаг байгууллага биш, өөрөө санхүүгийн хувьд босч чадахгүй юм биш. Тэхлээр бодлогын хувьд л зохицуулах гэж энэ холбоог байгуулсан юм ... Ганди гишүүн нэлээн тодорхой их юм хийсэн...

Т.Ганди: ... тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд интеграцчилсан байдлаар сургах хэрэгтэй ...

С.Чинзориг (Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд): .. Аль ч засгийн газрын үед бол тахир дутуу иргэд, ялангуяа нийгмийн эмзэг одоо бүлэг рүү хандсан, ийм онцгой анхаарлаа хандуулж байсан тийм засгийн газар байхгүй байсан гэж би ... үзэж болно.

Т.Ганди: ... эрх зүйн хүрээнд тахир дутуу иргэдийн талаархи бодлого бол ... нийгмийн хамгааллын мастер төлөвлөгөөнд суулгаж өгөөд байна....

С.Чинзориг: цаашид дэвшүүлж байгаа нэлээд асуудал байна.... холбооны дэргэдэх нөхөн сэргээх төвийг бас тоног төхөөрөмжийг сайжруулахад төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх гэсэн асуудал төлөвлөж байна.

"Нээлттэй микрофон" ердөө л төр засгийн сурталчилгаа болж хувирчээ. Уг нь энд тахир дутуу иргэд анхдагч баймаар. МТДИҮХ-ны ажлыг тэднээр дүгнүүлж, хэрвээ дарга нар шиг бэлэн ярьж чадахгүй бол асуулт тавиад, янз бүрийн санал бодлыг тусгахыг сэтгүүл зүй гэж нэрлэх байх. Тэрнээс биш МТДИҮХ-ны дарга нарыг ингэж яриулахыг PR гэж нэрлэнэ. Бас нэг зүйл: Сүүлийн хэдэн сар Т.Ганди гишүүн зогсоо зайгүй бэлэг тарааж явааг юугаар тайлбарлах вэ? Энэ орой бүр нэг хувцасны шошго уншиж өгч харагдсан.

Төрийн бус энэ байгууллага төрийн байгууллагын үргэлжлэл болов уу? Хэдэн байгууллага байхыг хүртэл шийдэж байна. Ямар нэгэн альтернатив, маргаан байхгүй. Хяналт бүр байхгүй. Энэ бол нийтлэг хандлага. Төрийн бус байгууллагын тэргүүнүүдийн ихэнх төрийн албан тушаалтан, сайд дарга нар байдаг.

2003.10.20. Даваа. МҮТВ. "Хэрэглэгчийн цаг"

МХЭАХНҮХ-ээс Төв аймгийн Зуунмод суманд зохиосон семинарын тухай сурвалжлага. (Төгсгөлд нь "МҮТВ, 2003" он гэснээс өөр нэргүй. Бэлтгэсэн студи, сэтгүүлчийн нэр, хаяг байсангүй). Нийгэмлэгийн тэргүүн нь УИХ-ын гишүүн Гомбожав юм байна. Төрийн ба төрийн бус байгууллагын зааг ялгаа, үүрэг хариуцлага байхгүй болж байна.

"25-р суваг" телевиз.

Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн нэвтрүүлэг.

УНХГ, аймаг дүүргийн нийгмийн халамжийн газрын дарга нар Англид яваад ирсэн бичлэгийг үзүүлэв.

"МТ" студид бэлтгэжээ.

2003.10.08. Лхагва

ТВ5. Мэдээллийн хөтөлбөр.

Гишүүн Т.Ганди эмзэг бүлгийнхэнд 10 сая төгрөгийн хувцас, тэрэг гардуулав. "Бусдыг баярлуулах шиг сайхан юм хаа байхав".

2003.10.13. Даваа

МҮТВ. "Цагын хүрд"

- Олон улсын цагаан таягтны өдөр болно гэсэн сурвалжлага... МТДИБҮХ маш олон ажил зохиов... "Өөдрөг эхлэл" хоршооны ажил... МТДИБҮХ нийтлэлийн уралдаан зарлаж шалгаруулав... Солонгосоос ирүүлсэн дулаан хувцас тараав.

2003.10.18. Бямба

МҮТВ.

"Гэгээн сэтгэлийн үзүүрт" захиалгат нэвтрүүлэг.

Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төслийн нэвтрүүлэг. УИХ-ын гишүүн МТДИБҮХ-ны ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн Т.Гандийн яриагаар эхэлж байна. "Ротари" клубийн тусламж гардуулж байгаа тухай сурвалжлага. Бусад сурвалжлагууд.

"Мөнх тэнгэр" студид бэлтгэжээ.

Гэтэл 10-р сарын 15-нд "Цагаан таягтны өдөр" Хараагүй иргэд жагсаал цуглаан хийсэн байна. "Төр засаг ичихгүй бол бидэнд алдах зүйл байхгүй", "Т.Ганди та хараагүйчүүдээр шоудахаа больё", "Хараагүйчүүд төр засгийн дуулгавартай зарц боол биш", "Чинзориг ба түүний багийнхан төслийн 1,2 сая доллараар түрийвчээ зузаалахаа больё" гэх мэт урианууд барьжээ. МҮТВ ба бусад телевизүүдийн сурталчилснаар төр засаг тэгэж сайхан ажилллаж байхад, Азийн хөгжлийн банкны 1,2 сая долларын төсөл хэрэгжиж байхад ийм юм болжээ. Тэр орой "Цагийн хүрд" таг дуугүй өнгөрөөв. Харин "25-р суваг" телевиз, TV5: Цагаан таягтны өдрөөр тайван жагсаал хийж өргөх бичиг барилаа.... Гэтэл тэр оройдоо өлсгөлөн болоод хувирчихсан байжээ.

2003.10.16. Пүрэв

Энэ өдөр хараагүйчүүдийн өлсгөлөн үргэлжилжээ.

- "Цагийн хүрд" таг дуугүй өнгөрөөв
- "TV5" таг дуугүй өнгөрөөв
- "25-р суваг" телевиз. "Үдшийн мэдээ"-гээрээ үзүүлэв.

UBS, ""City News"

Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгээс ... эрхийг хамгаалах "Цагаан таягтны өдөр"-өөр жагсаал хийж улмаар хэлмэгдэгсдийн хөшөөний дэргэд 6 хараагүй иргэн өлсгөлөн зарлаад байгааг үзэгч та бүхэн мэдэж байгаа. Энэхүү жагсаал цуглааныг хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг албаны хүмүүсээс тодруулсан юм.

Цагдаагийн ажилтан:

- Цагдаагийн байгууллагын зүгээс Жагсаал цуглаан хийх журмын тухай Монгол улсын хуулийн дагуу сануулж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахыг албан ёсоор мэдэгдэж

сануулсан байгаа. Эндээс Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга, мөн би өөрөө хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахыг албан ёсоор сануулсан. Ингээд энэ улсууд хэлмэгдэгсдийн хөшөөний хажууд ирээд өлсгөлөн зарлана гээд сууж байгаа. Энэ хүмүүсийнхээ эрүүл мэндийн талаар анхаараач ээ гэдгийг цуглаан зохион байгуулж байгаа гэх Чинбат, Баясгалан гэж хоёр хүнд хэлсэн. Яг одоо зохион байгуулж байгаа ямар улсууд байна вэ гэхлээр хэлэхгүй, хэлэхгүй ээ, мэдэхгүй гэдэг. Өлсгөлөн зарлахад ийм журам заавар байдаг гэхлээр тэрийг бид нар мэдэж байгаа гэдэг. Тэгээд бид зохион байгуулж байгаа улсуудад нь албан ёсоор уулзаж ярих гэхлээр олддоггүй, уулздаггүй. УИХ-ын гишүүн байсан. Хуучин энэ УИХ-ын гишүүн байсан Ша.Батбаяр энэ өдөр р орой 19 цагийн ирээд " та нарын энийг дэмжиж байна. Орой цагдаа нар ачна, хүн хүчтэй та нар олуулаа бай гэх мэтээр ийм ийм яриа ухуулга хийгээд явсан. Хэн зохион байгуулж байгаа нь олддоггүй. Өдөр замын хөдөлгөөн тодорхой хэмжээгээр саатуулсан, энэ зүйлүүд дээр тодорхой анхааруулж хэлж ярьсан байгаа.

Чингэлтэй дүүргийн засаг дарга М.Амарсайхан:

- Манай дүүргийн Засаг даргын тамгын газарт бол хандаж хоёр удаа албан бичиг ирүүлсэн байгаа. Эхнийх бол бид одоо бас учрыг сайн олохгүй, тэгээд тэр хөтөлбөрөө ирүүлж танилцуул гэсэн тийм хүсэлт тавьсан. Эний дараа бол мөн албан бичгээ хөтөлбөртэйгээ ирүүлсэн байгаа. Тэгээд ер нь жил бүр бол одоо бас хараагүйчүүдийн, дэлхий нийтээрээ хараагүйчүүдийн эрх ашгийг хамгаалах өдөр бол одоо өчигдөр байлаа тийм ээ. Энэ бол "Цагаан таягтны өдөр байлаа" гэж одоо тэмдэглэдэг. Бид одоо бас хараагүйчүүд маань одоо өөрсдийнхөө эрх ашгаа хамгаалах, өөрсдийнхөө асуудлаа одоо бас тавих, энэ өдрөөрөө одоо бас өөрсдөө эвлэлдэн нэгдэх, тийм ээ хамтарч ажиллах, ажил төрлөө ярих ийм чиглэлийн юугаар энэ уулзалтыг зохион байгуулж байна гэж бидэнд одоо ойлгуулсан. Бид тэгээд одоо зохих ёсны зөвшөөрлийг бол өчигдөр 13-15 цагийн хооронд бол өөрсдийнх хүссэн цагт нь бол одоо зөвшөөрлийг нь зохих журмын дагуу өгсөн. Ингэж өгсний дараа бол харин эд нар шал өөр зорилготой байсан нь бол одоо бас өчигдөр бол харагдлаа. Өөрөөр хэлбэл одоо биднийг одоо хуурсан гэдэг тийм, хуурсан. Яагаад гэвэл одоо Төв шуудангийн урдах замыг одоо 20 минут орчим бол одоо хааж, мөн одоо Засгийн газрын ордныг одоо бас гороолж тойрч тийм ээ, яг заасан газар одоо, заасан яг цагт нь бол одоо юуг бол хуулийн хүрээнд бол үйл ажиллагаа явуулаагүй, тэгээд энийг цуглааныг бол одоо жагсаал болгож ингэж яасан, цагаасаа өмнө эхэлсэн, ийм зөрчил бол гарсан. Энэ үүдээс бол бид энэ анх зөвшөөрөл авсан тэр Болдсайхан гээд хүн байгаа, тэрийг, тэдний менежер Баясгалан гээд одоо бас манайхан танилцуулсан энэ хүмүүсийг бол бид олж уулзах гээд олж уулзаж чадаагүй. Өөрснөө ингээд алга болсон. Тэгээд ямар хүмүүс хаана зохион байгуулж байна гэдэг нь бол мэдэгдэхгүй байсан. Харин орой 18 цагийн үед эд нар Засгийн газрын ордны баруун талд бол бас нэг жижиг майхан бариад суусан л даа. Энд бол харин одоо эний цаана хэн байгаа юм, хэн зохион байгуулсан гэдэг нь бол бидэнд бол мэдэгдсэн, за танигдсан гэх юм уу даа, тийм ээ. Яагаад гэвэл тэнд Ши.Батбаяр гэж урьд нь бол одоо урд нь засгийн газрын, эвслийн засгийн газрын үед бол ажиллаж байсан хүн байгаа, тийм ээ. Энэ хүн өөрөө бол жип машинтай ирээд, энэ хүмүүстэй уулзаад, та бүхэн энэ одоо тэмцлээ үргэлжлүүл, ер нь буцаж няцаж болохгүй, бид одоо хэлснээрээ байгаа гэх маягийн одоо юм хэлээд ингээд явсан. Тэгэхлээр энэ одоо тахир дутуу хүмүүсийг бол энэ цагаан таягтны өдрөөр нь далимдуулж одоо эднийг өөрсдийг нь дооглож эд нараар одоо, улс төрийн зорилгоор эднийг, энэ хүмүүсийг ашиглаж байна гэдэг нь одоо бас харагдсан. Өөрөө тэгэж хэлчихээд, тэгээд одоо тахир дутуу ерөөл ийм хүмүүсийг одоо шөнө гадаа одоо хонуулдаг тээ, өөрөө тэгээд мэдээж Ши.Батбаяр гэртээ хариад дулаан гэртээ тэгээд унтаж байгаа шүү дээ, тээ. Ингэж одоо улс төр одоо хийж болохгүй ээ"

"Үндэсний" гэсэн телевиз бүр 1999 онд бий болсон. Гэтэл одоо улс орон даяар нэвтрүүлгээ хүргэдгийг эс тооцвол Засгийн газрын телевиз. Удалгүй "олон нийтийн" гэсэн телевиз бий болохнээ. Гагцхүү олон нийтийн зүгээс нөлөөлөх механизм байхгүй бол Засгийн газрын телевиз хэвээрээ байх болно. Удирдах зөвлөлд нь олон нийтийг буюу төрийн бус байгууллагыг төлөөлсөн ганц хүн оруулаад юу ч өөрчлөгдөхгүй (одоо мэдэгдэж байгаа хуулийн төсөлд энэ тухай огт байхгүй). Тэгэхлээр олон нийтийн өргөн нэвтрүүлгийн гол хүчин зүйл нь телевизэд өөрт нь биш (дээрээс юуг хэлнэ, тэгэж өөрчлөгдөнө) биш, төр засагт биш (сонгууль ойлгосон тул тун удахгүй олон нийтийн болгоно), гагцхүү олон нийтэд байна.

Манайд олон нийтийн нэр зүүсэн телевиз олон жил үйл ажиллагаа явуулж байгааг дээр хэлсэн. Энэ бол UBS. Нийслэлийн ИТХ-д харьяалагддаг. Бас нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах зөвлөл гэж байдаг юм байна. Харамсалтай нь Улаанбаатар хотын "олон нийт" энэ телевизэд ямар ч хамаа байхгүй.

10-р сарын эхээр нийслэлийн ИТХ-аас хэвлэл мэдээллийн байгууллагын хувьчлалын тухай хэлэлцжээ. Менежментийн хувьчлалыг арга замыг сонгосон байна. Цаагуураа маш юм болж байгаа нь тодорхой. Нийслэлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн хувьчлал нийслэлийн хөдөлмөрчдийн нүднээс далдуур, шуудхан хэлэхэд нууц байдалд шийдэгдэж байна. Нийслэлийн "олон нийт"-ээс огт асуугаагүй. Энэ бол уурын зуух юм уу дуусаагүй барилгын хувьчлал яавч биш. Нийслэлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдөө энэ талаар таг дуугүй.

Бүх телевизүүд бүгдээрээ таг дуугүй өнгөрөөсөн нэг үйл явдал байна. 9-р сарын төгсгөл, 10-р сарын эхээр болсон "Монгол төрх" сониныг тойрсон үйл явдал юм. Энэ бол хэвлэл мэдээллийн эзэмшлыг хөндсөн сэдэв учраас зөвшөөрөөгүй гэж ойлгож байна.

2003.09.21
UBS "City News"

- Нийслэлийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр хотын захирагч М.Энхболд "Улаанбаатар хотын нягтралыг сайжруулах бодлого явуулж байгаа, үүнийг иргэд "зөв зүйтэй талаас нь тэр бүрий бас ойлгохгүй байгаа тохиолдол байна.... Энэ бүгдийг ойлгуулах хэрэгтэй байна...." гэсэн үүрэг даалгаврыг нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагад өгчээ.

2003.10.05. Ням
МҮТВ

"Нэвтрүүлгээс үзэгч хүртэл" шууд ярилцлага. Дэд бүтцийн яам, харилцаа, холбооны зохицуулах зөвлөл, "МЦХ" компани, мэргэжлийн хяналтын байгууллага, МҮТВ, "25-р суваг" телевиз, UBS ба кабелийн телевизийн ажилтнууд оролцож телевизийн нэвтрүүлгийн хураамжийн тухай ярилцлаа. "Студи-600"-д болжээ.

Сурв: программын зохицуулах тусгай байгууллага байдаг гэж ярьдаг шүү дээ. Манайд тийм байгууллага үгүйлэгдэж байгаатал байж болох уу?

Баярсүрэн: Байж болно. Эфийн 5 телевиз хоорондоо программаа яаж зохицуулдгийг би мэдэхгүй ... Программын талаасаа ч зохицуулалт хэрэгтэй... Эрх зүйн акт өнөө маргаашгүй хэрэгтэй...

Төгсгөлийн тайлбар: ... Энэ янзаараа өнөөдөр 30-аар тоологдох кабелийн телевизийн тоо үүнээс цааш өсөх хандлагатай байна. Зах зээл, өрсөлдөөн, ашигтай бизнес гээд аймаг сум бүрт, албан байгууллага, хувь хүн бүрт телевиз байгуулахыг зөвшөөрөөд байх уу? Энэ бол зөвхөн зах зээлийн хуулиар зохицуулагдах худалдааны салбар биш. Энэ бол цаана нь үндэсний эрх ашиг хөндөгдсөн, хүнээ төлөвшүүлэх чухал бодлого давхар давхар явагдаж байх ёстой онцгой салбар юм. Тэнд программын зөвшөөрлийг хэн өгөх вэ гэдэг асуудал цагаан цэг хэвээрээ үлдэж байна...". Нийгэм, эдийн засгийн ерөнхий редакциас бэлтгэжээ. .

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийг бий болгохын зөвхөн телевизийг өөрчлөн байгуулах хангалтгүй бололтой. Төгсгөлд нь үүнтэй холбоотой нэг санаа хэлье. Арилжааны телевиз хүчтэй, олон давуу тал бий. Тэгвэл үүнийг алдагдуулахгүйгээр арилжааны телевизийн дотор олон нийтийн студи, түүнийг нэвтрүүлэг, цагийг бий болгomoор санагдаж байгаа юм. Жинхэнэ олон нийтийн телевизийн загвар болог.